


МОНГОЛ ХЭЛНИЙ ОЙРОЛЦОО ЗЭРГЭД ДЭХ ТЭМДЭГ НЭРИЙН ҮҮРЭГ УТГА

Б. Мөнгөнцэцэг*

Өгүүлбэр нь ямар нэгэн үйл явдлын тухай мэдээлэх төдийгүй уг өгүүлбэрийн агуулгад хандах тухайн өгүүлэгчийн сэтгэлийн байдал, субъектив хандлага, таашаал үнэлэмжийг агуулдаг. Иймд баймж чанар нь хэлний мэдээлэх нэгж болох өгүүлбэрийн гол шинжийн нэг юм. Баймж нь өгүүлэгчийн үзэл бодол, үнэлэмж, сэтгэлийн хөдөлгөөнийг илтгэх учраас мэдэхүүнд хамаарах бөгөөд баймж үнэлэмж нь хэлний их бага буюу задгай битүү дөрвөн зүйл нэгжийн аль алинаар нь илэрч болдог агуулга багтаамжийн хувьд өргөн хүрээтэй ай юм. Хүн тухайн юмын шинж чанарыг тодорхойлох, мөн хэд хэдэн юмыг харьцуулахдаа өөрийн хандлага, үзэл бодол, санал, хүсэл эрмэлзэл, үнэлэмж сэтгэгдлээ шингээж илэрхийлснийг баймж гэдэг. Баймжийг алетик (бодомжид яригдаж байгаа мэдээллийн зайлшгүй, санамсаргүй, бололцоотой, бололцоогүйн байдлыг харуулдаг), эпистем (бодомжид өгүүлэгдэж буй мэдээллийн хүлээн зөвшөөрөгдсөн, үндэслэгдсэн байдлыг нь харуулдаг), аксиологи (бодомжийн холбоосын шинжийг үнэт зүйл, үнэлэмжийн үүднээс тодорхойлно), деонтик (хэрэв бодомжид ямар нэгэн үйлдлийн тухай ярьж байвал энэхүү үйлдлийн шинжийг тодруулж байгаа гуйлт, зөвлөмж, тушаал, зарлиг, хориг гэх мэтээр илэрнэ) модаль шинж¹ гэж ангилжээ.



Тухайн өгүүлбэрт ямагт үнэлэмж баймж давхцан буюу зэрэгцэн оролцож байдаг. Эрдэмтэн Ю.Мөнх- Амгалан монгол хэлний баймжийн айг төвийн ба захын тогтолцоо гэж хоёр хуваан, тус бүрийг мэдэгдэхүүн ба хэлэгдэхүүн гэсэн зогсонги тал, мэдэхүүн ба хэлэхүүн гэсэн хөдлөнги тал гэсэн дөрвөн талаас найман хэсэг болгон судалжээ. Тэрээр, “Баймжийн айн захын тогтолцоо нь хэлэхүүн талаас өгүүлэмжийн агуулга ба үнэлэмжийн харьцаанд тулгуурлах нэмэлт баймж чанарыг илэрхийлсэн байна.

* МУИС-ийн МХСС-ийн докторант

¹ Отгонбаяр М. (1998) *Логик*. 48-51 х., Улаанбаатар.

Баймжийн айн захын тогтолцооны нэмэлт баймж чанарт холбогдох хамгийн гол харьцаа бол өгүүлэгчийн үнэлэмж илэрхийлсэн утга болно. Үнэлэмжийн субъект ба объектын хоорондох тодорхой харьцааг тогтоосноор үнэлэмжийн шинж чанар, агуулгыг тодорхойлж болно. Үнэлэмжийн шинж чанар, агуулга нь янз бүрийн субъектив баймж утгаар арвин”² гэжээ.

Аксиологи үнэлэмжийн нэгж нь эерэг (сайн)-ээс сөрөг (муу) хүртэлх үнэлэмжийн бүхий л утгыг багтаадаг бол алетик үнэлэмжийн нэгж нь эргэлзэх ба итгэлтэй байх гэсэн утгазүйн хоёр зүйл бүлэг баймж утгын хүрээг хамардаг³ Ер нь “...үнэлэх шинж (оценочность) нь баймжийн утгазүйтэй зөвхөн хэсэг бусгаар холбогдоно. Иймд үнэлэх шинжийг баймж чанар лугаа харилцан үйлчилж буй утгазүй – хэрэглээний онцгой хүрээ хэмээн ойлгож болох юм”⁴

Ямар нэгэн үнэлэмж заасан утга бүхий тэмдэг нэр субъектив баймж утга лугаа ихээхэн холбогддог тухай судлаач В.Н.Телия⁵, Б.Чулуундорж⁶, Ю.Мөнх - Амгалан⁷, Ж.Баянсан⁸ нар тэмдэглэсэн нь бий. Түүнчлэн эрдэмтэн М.Базаррагчаа “...мэдэхүүний нийлмэл өгүүлбэр нь бодот үйл явдал, хүний үйлдэл, дүгнэлтээс бүтэх...” тухай өгүүлээд, монгол хэлний нийлмэл өгүүлбэрийг “...хоёр өгүүлбэрийг харьцуулан зэрэгцүүлээд үнэлэх оруулбар бүхий нийлмэл өгүүлбэр, тайлбарлан ЗНӨ, дүгнэлт бүхий

² Мөнх-Амгалан Ю. (1998) Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. 220- 222 х., Улаанбаатар.

³ Вольф Е.М. (1985) Функциональная семантика оценки. стр. 11-13, Москва.

⁴ Бондарко А.В. (1990) Модальность. /Вступительные замечания// Теория функциональной грамматики. Темпоральность. Модальность. стр. 61, Ленинград.

⁵ “...үнэлэн тодорхойлох шинж чанар бүхий мэдээллийг тодорхой бус хэлбэрээр өөртөө үргэлж агуулж байдаг” Телия В.Н. (1981) Типы языковых значений: связанное значение слов в языке. стр. 210, Москва.

⁶ “Орос хэлэнд юм, үзэгдлийн талаарх хүний үнэлэлтийг дайвар үгээр илэрхийлнэ. Ой, Андрей, не зря (В.Р) Это правильно. Эдгээр нь монгол хэлний “Тэр чинь тун буруу, хүү минь” (Д.Р), Хүү минь, тэр зөв шүү. (А.Д) өгүүлбэртэй төсөөтэй байна. Орос хэлэнд хүн, юмс үзэгдлийн талаарх өгүүлэгч хүний үнэлэлт дүгнэлтийг тэмдэг нэрээр туслах үйл үгтэй илэрхийлэх явдал ч бий. Он был прав. (Ю.Ч) Энэ нь монгол хэлний “Хөгшин минь, хүүгийн зөв байж”, “Үнэндээ ч өвгөн буруутай биш байсан юм” (Н.Б) өгүүлбэртэй предикатив шинжийг илэрхийлсэн байдлаар адилхан билээ.” Чулуундорж Б. (1985) Орос хэлний утга зүйн айн тайлбар бичиг. 51-52 х., Улаанбаатар.

⁷ “...үнэлэмж заасан тэмдэг нэр (оценочные прилагательные) нь ямар нэгэн үйл хөдлөл гүйцэтгэх боломж, хүсэл тэмүүлэл, бэлэн байх шинж, шаргуу хичээлттэй байх чанар зэрэг олон баймж утга илэрхийлдэг байна. Тэрчлэн тэмдэг нэрийн утгазүйг ерөнхийд нь ажиглахад өгүүлэгчийн үнэлэмжийг ямар нэг байдлаар илэрхийлсэн нийтлэг талтай юм. Жишээлбэл,

а) Юм үзэгдлийн шинж чанар, үйл хөдлөл, гүйцэтгэх байдал төлөвийг үнэлсэн. Жишээлбэл: амар, хялбар, хөнгөн, хүнд, хэцүү, түвэгтэй

б) Таатай таагүй үнэлгээний үүднээс юм үзэгдлийн шинж чанарыг илэрхийлсэн: Жишээлбэл: сайхан, үзэсгэлэнтэй, аятайхан, аймшигтай, аймаар

с) Бололцоот байдлын үүднээс юм, үзэгдэл, үйл хөдлөлийн болц, явц, байдлыг үнэлсэн. Жишээлбэл: боломжийн, аюулын, гайгүй г.м.” Мөнх-Амгалан Ю. Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. 223 х., Улаанбаатар.

⁸ “сайн, муу, гайхамшигтай, гутамшигтай зэрэг ерөнхий үнэлэмжийг илэрхийлсэн үгс нь зүйрлэлийн санааг өөртөө агуулдаггүй. Харин нэг юмын шинж чанарыг өөр юмын шинж чанар болгон ишлжүүлж нэрлэлт үүсгэх үед л эдгээр ерөнхий үнэлэмжийн нэрс нь зүйрлэлийн утгатай болно. ...тэмдэг үг нь адилтгалын гишүүн болбол эерэг, сөрөг үнэлэмжийн илтгүүр болж чадна” Баянсан Ж. (2002) Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ. 32 х., Улаанбаатар.

ЗНӨ, оруулбар бүхий ЗНӨ, санал сэтгэгдлээ оруулсан ЗНӨ, харьцуулан дүгнэсэн ЗНӨ...⁹ гэж ангилан, өгүүлбэр судлалын түвшинд үнэлэмжийн айн шинжийг чухалчлан үзсэнийг онцлон дурдууштай.

Баймжийг үйл үг, тэмдэг ба тооны нэр, авиа ба дүрс дуурайх үг илтгэдэг болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг. Мэдэхүүний талаас, ойролцоо зэргэд нь тухайн үйл явдлыг өгүүлэгчийн үзэл бодол, баймж, үнэлэмжийн үүднээс дүгнэсэн өгүүлбэрийн цогц юм. Олонх судлаач баймж чанар нь өгүүлбэрийн гол шинжийн нэг болох өгүүлэхүүн чанартай салшгүй холбоотой гэж тодорхойлжээ.

Хуурамч амрагийн

Хугацах нь амархан

Хуурай модны

Хугарах нь амархан

гэхэд “хуурай мод” гэдгийг тонгоргон “мод хуурай” болгож болно. Юу гэвэл “Мод хуурай байна. Мод хуурай байна шүү дээ. Мод үнэхээр хув хуурай байлаа” гэх мэтээр өгүүлэхүүн буюу тэмдэг нэр, үйл үг нь элдэв баймжит утгыг илтгэж байна. Иймд бид уг өгүүлэлд тэгш хэмт найруулга бүхий ойролцоо зэргэд дэх тэмдэг нэрийн утга үүргийг тодруулсан болно. Үүнд:

1. Адилтгасан үйл явдлыг үнэлсэн тэмдэг нэр нь шууд нэрлэлтээр илэрсэн:

➤ Өгүүлбэр + тэмдэг нэр:

1. шинж чанар: *Давааг давсан хойно*

Цаад руу нь буух амархан

Ажлыг хийсэн хойно

Дүнгий нь дуулах амархан

гэхэд эхний өгүүлбэр нь бодот үйл явдлыг тусгасан бол эцсийн өгүүлбэр (амархан) -г уг адилтгасан үйл явдлыг хүн үзэж оролцохдоо “амархан” хэмээн дүгнэж байна. Өөрөөр хэлбэл, “давааг давах, цаад руу нь буух”, “ажлыг хийх, дүнгий нь дуулах” хоёр үйлийг амархан – амархан бишийнх нь хувьд харьцуулсны үндсэн дээр “цаад руу нь буух”, “дүнгий нь дуулах” нь амархан гэсэн нэг оюун дүгнэлт болгосон бөгөөд улмаар “үйл хэргийнхээ үр шимийг үзэх сайхан” гэсэн санаа бүхий ойролцоо зэргэд бүтээжээ.

Хаяанд сууж

Хавирга мөлжих бэрх

Үүдэнд сууж

Эрүү мөлжих бэрх

гэхэд “ядуу буурайгийн зовлон”-г хүн суухаас цээрлэдэг газарт (хаяа, үүд) суугаад мах муутай, идүүргүй “хавирга, эрүү”-г мөлжихтэй холбон ёгтлон илэрхийлэхийн зэрэгцээ адилтгагдсан хоёр янзын байр байдлыг “хэцүү, хүчир, амаргүй” гэсэн утга бүхий шинж чанар заасан тэмдэг нэрээр үнэлж зэргэд бүтээсэн байна.

2. өнгө зүс: *Батгана суухгүй падан хар*

Ялаа суухгүй яндан хар

гэхэд “хэн ч тоохгүй, голох, муулах, чамлах, дорд үзэх” гэх санааг илэрхийлэхдээ тухайн юмын шинжийг илтгэх “хар” гэсэн өнгө заасан тэмдэг нэрийн утгыг эрчимжүүлэхийн зэрэгцээ тэмдэг нэрийн адил зэргээр тодорхойлж үнэлсэн байна.

⁹ Базаррагчаа.М. (1996) *Монгол хэлний нийлмэл өгүүлбэрийг ангилах тухай асуудалд*. 9-55 х., Улаанбаатар.

3. хэлбэр дүрс: *Харахад царайгүй харчгар*

Үзэхэд үзэмжгүй үрчгэр

гэхэд “тэгш хэмээ алдах, гоо үзэмжгүй” гэсэн санааг илтгэхдээ бодот үйл явдлыг „харчгар-үрчгэр” хэмээх дүрслэх утгатай үүсмэл тэмдэг нэрээр үнэлэхийн зэрэгцээ энэ нь илгээн үйлдэгч (өгүүлэгч)-ийн санааг илэрхийлэх тул бодит баймжийг илтгэсэн дүгнэлт өгүүлбэр болно.

4. тоо хэмжээ: *Зээгээ танихгүй өнөр олон*

Зээрдээ танихгүй баян олон

гэхэд эхний өгүүлбэр нь бодот үйл явдлыг тусгасан бол эцсийн өгүүлбэрт уг адилтгасан үйл явдлыг хүн үзэж оролцохдоо “олон” хэмээн дүгнэж байна.

➤ Өгүүлбэр + харьцангуй тэмдэг нэр:

Бадарчин явбал балагтай

Батгана суувал өттэй

гэхэд эхний өгүүлбэр нь бодот үйл явдлыг тусгасан бол эцсийн өгүүлбэрт уг адилтгасан үйл явдлыг хүн үзэж оролцохдоо “балагтай, өттэй” гэсэн харьцангуй тэмдэг нэрээр үнэлж, улмаар “муу юмны уршиг их” гэсэн санааг илтгэжээ.

1.1.б. Адилтгасан үйл явдлыг үнэлсэн тэмдэг нэр нь шууд бус нэрлэлтээр илэрсэн:

➤ өнгө заасан: *Санаад санаад саарал*

Бодоод бодоод буурал

гэхэд эхний өгүүлбэр нь бодот үйл явдлыг тусгасан бол эцсийн өгүүлбэрт уг адилтгасан үйл явдлыг хүн үзэж оролцохдоо “хөширөх” гэсэн утгыг үсний өнгөөр нь “буурал, саарал” хэмээн дүгнэж, улмаар “юмыг идэвхтэй хийхийн оронд хий бясалган бодож суух хэрэггүй” гэсэн санааг илтгэжээ.

➤ шинж чанар: *Түргэн нь түүхий*

Хурдан нь хуумгай

гэхэд эхний өгүүлбэр нь бодот үйл явдлыг тусгасан бол сүүлчийн өгүүлбэрийн үнэлэмж илтгэсэн тэмдэг нэр (шинж чанар заасан) „түүхий” нь адилтгасан утгаар орж, улмаар „учир явдалд хааш яаш ханддаг, хөнгөн мөчид, цалгай” гэсэн санааг илтгэжээ.

1.2.а. юмыг шинжээр нь тодорхойлон үнэлсэн тэмдэг нэр нь шууд нэрлэлтээр илэрсэн:

Жинхэнэ нэр + орон зай заасан тэмдэг нэр:

Буянгүй хүнд бурхан хол

Сүсэггүй хүнд сүм хол

“дургүйд хүчгүй” гэсэн санааг илтгэхдээ юм үзэгдлийн шинжийг “хол” гэсэн орон зай заасан тэмдэг нэрээр тодорхойлон үнэлэхдээ “буянгүй хүн - бурхан, сүсэггүй хүн – сүм” хоёрын харш шинжид тулгуурлан сэтгэл зүйн учир шалтгааныг нээжээ.

Жинхэнэ нэр + шинж чанар заасан тэмдэг нэр:

Богдоос боол нь хэцүү

Хаанаас хаалгач нь хэцүү

“богд, боол”, “хаан, хаалгач” хоёрыг хэцүү - хэцүү бишийнх нь хувьд харьцуулсны үндсэн дээр “боол”, “хаалгач” нь хэцүү гэсэн нэг оюун дүгнэлт болгосон бөгөөд улмаар “аливаа юм жижигрэх, доошлох тусам хэцүү түвэгтэй болдог” гэсэн санаа бүхий ойролцоо зэргэд бүтээжээ.

Жинхэнэ нэр + тоо хэмжээ заасан тэмдэг нэр:

Баригдаагүй загасны бараа нь их

Бариагүй гэрийн унь урт

гэсэн цогцолборт хүний хүсэл шунал, залхуу хойрго байдлыг илтгэсэн ёгт далд санааг илтгэхдээ юм үзэгдлийн шинжийг “*их, урт*” гэсэн хэмжээ заасан тэмдэг нэрээр тодорхойлон үнэлж, “*а. өөрт бус юм бүхэн сайхан харагдах; б. ажил хийхээс хойш суух*” гэсэн санааг тус тус илтгэжээ.

Харьцангуй тэмдэг нэр + шинж чанар заасан тэмдэг нэр:

Ганц дээлт барилдаач

Ганц морьт уралдаач

гэхэд юмын шинжийг шинжээр үнэлж, улмаар “*а. хэрээ мэдэхгүй их санаархах, б. хяслыг хүслээр давах, в. хээгээ алдах, г. ядуу хүний од шүүрэх хүсэл шунал*” гэсэн санааг илтгэсэн байна.

Тэмдэг нэр+ тэмдэг нэрийн үүргээр орсон орон цагийн нэр:

Ааш зангийн номхон дээр

Адуу малын тарган дээр

гэхэд шинж чанар заасан тэмдэг нэр (номхон, тарган) -ийн дараа орсон “*дээр*” орон цагийн нэр нь тэмдэг нэрийн үүргээр орсны улмаас юмын шинжийг шинжээр нь тодорхойлж, улмаар өгүүлэгчийн үнэлэмжийг илтгэсэн байна.

Ямааны махны халуун нь Ø (дээр)

• *Ямарваа үйлийг түргэн нь Ø (дээр)*

“*халуун нь, түргэн нь*” - нөгөө гишүүнийхээ утга үүргийг давхар үүрсний улмаас хоосноор илэрснийг сэргээвэл тэмдэг нэрийн үүргээр орсон орон цагийн нэр “*дээр*” нь юмын шинжийг шинжээр үнэлсэн нь тодорхой харагдах болно.

1.2.б. юмыг шинжээр нь тодорхойлон үнэлсэн тэмдэг нэр нь шууд бус нэрлэлтээр илэрсэн:

Жинхэнэ нэр + шинж чанар заасан тэмдэг нэр:

Хөлөлдөггүй үхрийн хүзүү сул

Хөдөлдөггүй хүний бие сул

гэхэд тэнхээ муутай, бяр чадалгүй байхын учир шалтгааныг “*хөдөлдөггүй-хөлөлдөггүй*” - гэс үүтгэн адилтгаж гаргасан бөгөөд үхрийн хүзүү, хүний биеийг “*улцгар, дорой, чадал муутай*” шинжээр нь тодорхойлон үнэлж, улмаар “*бие сул, дорой буурай, хүчгүй*” гэсэн санааг илтгэсэн байна.

Мөргөх бухын нүд улаан

Хорлох хүний харц зэвүүн

гэхэд “*санаа нь нүдэн дээрээ, алив юмны сайн муу нь гадаад шинжээрээ илэрдэг*” гэх ерөнхий санааг илтгэхдээ тухайн юм үзэгдлийн шинжийг “*улаан*” гэсэн өнгө заасан тэмдэг нэр, “*зэвүүн*” гэсэн шинж чанар заасан тэмдэг нэр, “*мөргөх бух, хорлох хүн*” хийгээд тэдгээрийн “*нүд, харц*”-ны байдалтай хоршуулан тус тус тодорхойлон үнэлжээ.

“Чоно шигэндээ зөв

Шонхор болжмртоо зөв

Нохой явган

Гахай нүцгэн” гэх зэрэг жишээ цөөн боловч тохиолдоно.

Дүгнэлт

Монгол хэлний ойролцоо зэргэдийг зүйр цэцэн үгийн жишээн дээр авч үзвэл мэдэхүүн, хэлэхүүний талаас ихээхэн баялаг хэрэглэгдэхүүнтэй боловч энэ талын судалгаа бага хийгдсэн байна. Ойролцоо зэргэдийг мэдэхүүний талаас авч үзвэл тухайн үйл явдлыг өгүүлэгчийн үзэл бодол, баймж, үнэлэмжийн үүднээс дүгнэсэн өгүүлбэрийн цогц юм.

Монгол хэлний ойролцоо зэргэдэд үгсийн ай дотроос ихэвчлэн тэмдэг нэрээр адилтгасан үйл явдал болоод юмс үзэгдлийг шинжээр нь тодорхойлон үнэлж байна. Тодруулбал, “*сайн хүн*” гэхэд сайн гэдэг нь хүний зогсонги буюу байвал зохих шинжийг нь тодорхойлсон үнэлэмж болох ба улмаар хувь хүн тэр хүнийг л сайн гэж үзэж байгаа хэрэг юм. “*Явсан минь сайн боллоо*” гэвэл энэхүү шинж чанар заасан тэмдэг нэр нь уул үйл явдлыг үнэлж байна. Үнэлэмж илтгэх тэмдэг нэрийг утгын хувьд авч үзвэл ихэвчлэн шинж чанар заасан тэмдэг нэр нь шууд нэрлэлтээр илэрч, улмаар бодот үйл явдал хийгээд юмс үзэгдлийг шинжээр нь тодорхойлон үнэлж байгаа нь хэлний баримтаас харагдаж байна.

SUMMARY

Parallel Mongolian language synonyms evident in proverb examples and other materials for cognition and tongue have hardly been researched.

Speech side parallel synonyms are based on a reality, human activity and conclusions determined by their characters. The Mongolian language's parallel synonyms ideas are written by adjectives in a result of direct and indirect speeches. Parallel synonyms which evaluate the comparative activities are written by adjectives of quality. Parallel synonyms modal meanings which are determined things by characters are written by adjectives of color, quantity, place and could also be written using mixed grammar. The materials prove that adjectives of place can be understood by their modal meaning.